



ХЭНТИЙ АЙМГИЙН  
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

Мөрөн сум

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/21

Хогны машин хүлээн авах  
комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Сумын Засаг даргын 2026 оны 02 сарын 02-ны өдрийн А/20 тоот захирамжаар байгуулагдсан Сумын үнэлгээний хорооны 2026 оны 03 сарын 02-ны өдрийн 02 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. "ДУНДИ" ХХК нь сумын ОНХ сангийн хөрөнгө оруулалтаар "Хогны машин" нийлүүлэх ажлын тендерт ялж 2026 оны 03 сарын 25-наас 2026 оны 06 сарын 30-ны дотор хийж гүйцэтгэх гэрээ байгуулсан тул уг ажлыг хүлээн авах эрх бүхий сумын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга:	С.Энхсүх	Соёл сан хариуцсан нягтлан бодогч
Гишүүдэд:	Б.Баяртуяа	Нягтлан бодогч
	Б.Мягмаржав	"Номт баян мөрөн" ОНӨААТНҮГ Захирал
	Г.Наранбаатар	Жолооч
	А.Энхтөр	Аж ахуйн нярав

2. "ДУНДИ" ХХК -аас хүлээн авах Хогны машиныг гэрээний хавсралт болох техникийн тодорхойлолтыг үндэслэн бичиг баримт, дагалдах хэрэгсэл, өнгө үзэмж, чанар байдлыг нэг бүрчлэн шалгаж, фото зургаар баримтжуулан акт үйлдэж хүлээн авахыг комиссын дарга (С.Энхсүх)-д үүрэг болгосугай.

3. Хогны машиныг хөрөнгөнд бүртгэх, цаашид яаж ашиглах талаар санал боловсруулж танилцуулахыг нягтлан бодогч (Т.Баяртуяа), Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга (Ц.Болорцэцэг)-нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Н.НАМЖИЛНОРОВ